



МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2017 оны 11 дүгээр
сарын 24-ний өдөр

Дугаар 317

Улаанбаатар
хот

Гадаадаас 2018 онд авах ажиллах хүч,
мэргэжилтний эзлэх хувийг
тогтоох тухай

Ажиллах хүч гадаадад гаргах, гадаадаас ажиллах хүч, мэргэжилтэн авах тухай хуулийн 4.1.4, 7.3, Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хуулийн 14 дүгээр зүйлд заасныг тус тус үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:


1. Монгол Улсад 2018 онд үйл ажиллагаа явуулах аж ахуйн нэгж, байгууллагын нийт ажиллагчдын тоонд эзлэх гадаадын ажиллах хүч, мэргэжилтний хувийг хавсралт ёсоор баталсугай.

2. Энэ тогтоолын хавсралтад заагаагүй салбарт үйл ажиллагаа эрхэлж байгаа 20-иос дээш ажилчидтай аж ахуйн нэгж, байгууллагад гадаадаас авах ажиллах хүч, мэргэжилтний эзлэх хувийг тухайн байгууллагын нийт ажиллагчдын 5 хүртэл хувь байхаар тогтоосугай.

3. Аж ахуйн нэгж, байгууллагын гадаадаас авах ажиллах хүч, мэргэжилтний тоо энэ тогтоолын хавсралтаар баталсан хувиас илүү гарсан тохиолдолд Засгийн газарт оруулж шийдвэрлүүлж байхыг Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд С.Чинзоригт үүрэг болгосугай.

4. Гадаадаас авах ажиллах хүч, мэргэжилтнийг эрүүл мэндийн урьдчилсан төлбөрт үзлэгт хамруулж байхыг ажил олгогчид, эрүүл мэндийн үзлэгт хамруулах ажлыг хууль тогтоомжид нийцүүлэн зохион байгуулж, хяналт тавьж ажиллахыг Эрүүл мэндийн сайд Д.Сарангэрэлд тус тус үүрэг болгосугай.

5. Энэ тогтоолын хавсралтад заасны дагуу 2018 онд авах гадаадын ажиллах хүч, мэргэжилтний нийт ажиллагчдын тоонд эзлэх хувийг Засгийн газар хоорондын гэрээ байгуулах, тэндер зарлах, төсөл, хөтөлбөр хэрэгжүүлэхэд баримтлан хяналт тавих, буцаан гаргах ажлыг зохион байгуулж, улирал тутам Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яаманд тайлагнаж ажиллахыг холбогдох сайд нарт үүрэг болгосугай.




Монгол Улсын Ерөнхий сайд

Хөдөлмөр, нийгмийн
хамгааллын сайд

У.ХҮРЭЛСҮХ

С.ЧИНЗОРИГ

Засгийн газрын 2017 оны 317 дугаар
тогтоолын хавсралт



2018 ОНД АЖ АХУЙН НЭГЖ, БАЙГУУЛЛАГЫН НИЙТ МОНГОЛ АЖИЛЛАГЧДЫН ТООНД
ГАДААДААС АВАХ АЖИЛЛАХ ХҮЧ, МЭРГЭЖЛТНИЙ ЭЗЛЭХ ХУВЬ, ХЭМЖЭЭ

Салбар	Дэд салбар	Бүлэг	Анги	Эдийн засгийн үйл ажиллагааны салбарын ангилал	Нийт монгол ажиллагчдын тоо				
					20-30	30-50	50-100	101-200	201- түүнээс дээш
					Гадаадын ажиллах хүч, мэргэжилтний эзлэх хувь				
A				ХӨДӨӨ АЖ АХУЙ, ОЙН АЖ АХУЙ, ЗАГАС БАРИЛТ, АН АГНУУР					
	01	011		Нэг наст ургамлын тариалалт	10	15	20	25	30
		016	0162	Мал, амьтны ашиг шимийг авахад туслах үйл ажиллагаа	10	15	20	25	30
B				УУЛ УУРХАЙН ОЛБОРЛОЛТ					
	06	061	0610	Газрын тос, байгалийн хийн олборлолт	10	20	30	40	50
				Газрын тос, байгалийн хийн хайгуул	10	20	30	45	50
	09	099	0990	Уул уурхайн олборлолт, тэдгээрийн туслан гүйцэтгэх	10	20	25	30	35
C				БОЛОВСРУУЛАХ ҮЙЛДВЭР					
	13			Нэхмэлийн үйлдвэрлэл	20	20	20	25	25
	20			Хими, химийн төрлийн бүтээгдэхүүний үйлдвэрлэл	15	15	15	15	15
	23			Төмөрлөг бус эрдэс бодисоор хийсэн эдлэл үйлдвэрлэл	15	15	15	15	15
	24			Металл үйлдвэрлэл	15	15	15	15	15
	32			Бусад боловсруулах үйлдвэрлэл	15	15	15	15	15
	33			Машин, тоног төхөөрөмжийг угсрах, суурилуулах, холбогдох засвар үйлчилгээ	10	15	20	25	25
D				ЦАХИЛГААН, ХИЙ, УУР, АГААРЖУУЛАЛТ	10	20	30	35	40
E				УС ХАНГАМЖ, БОХИР УС ЗАЙЛУУЛАХ СИСТЕМ, ХОГ, ХАЯГДЛЫН МЕНЕЖМЕНТ БОЛОН ЦЭВЭРЛЭХ ҮЙЛ АЖИЛЛАГАА	10	15	20	25	30
F				БАРИЛГА					
	41	410	4100	Барилга угсралт	10	30	35	45	60
		421	4210	Төмөр зам болон авто замын байгууламж барих үйл ажиллагаа	10	30	35	45	60

Жич :

1. 5-20 хүртэлх монгол ажиллагчидтай аж ахуйн нэгж, байгууллага нь эдийн засгийн үйл ажиллагааны салбар харгалзахгүйгээр 1 гадаадын иргэн ажиллуулж болно.
2. Гадаадын хөрөнгө оруулалттай аж ахуйн нэгж, байгууллагын гадаадын хөрөнгө оруулагч хуулийн этгээдийн удирдах бүрэлдэхүүний 3 төлөөлөгч, гадаадын хөрөнгө оруулагч 1 хувь хүнийг хөрөнгө оруулалтын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагын тодорхойлолтыг үндэслэн энэ тогтоолд заасан хувь, хэмжээнд хамааруулалгүй хөдөлмөр эрхлэх зөвшөөрөл олгож болно.